

# “ХААН СОЁМБО АУДИТ” ХХК



## САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Рашаант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/206/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2025 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatar@audit.gov.mn](mailto:erdenebaatar@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88012671 Цахим хаяг: [ichinkhorlooga@audit.gov.mn](mailto:ichinkhorlooga@audit.gov.mn)

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа  
Утас: 99065668 Цахим хаяг: [info@khaansoyomboaudit.mn](mailto:info@khaansoyomboaudit.mn)

Гүйцэтгэсэн аудитор: Н.Ган-эрдэнэ  
Утас: 88115349 Цахим хаяг: [ganerdene108@yahoo.com](mailto:ganerdene108@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/215  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН РАШААНТ СУМЫН  
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Ч.ОТГОН-ЭРДЭНЭ ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Рашаант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд 14,787.1 мянган төгрөгийн бараа материал, 56,014.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн ажилтанд олгосон урамшуулал, хөрөнгөтэй холбоотой 18,155.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 4 зөвлөмжийг хүргүүлж ажилласан.

#### Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймгийн Рашаант сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь 2024 онд аймгийн Боловсролын газрын даргатай гэрээ байгуулан ажиллаж, хэрэгжилтийг 94 хувийн гүйцэтгэлтэй байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

67.3021567

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>221,345,904.89</u></b>	<b><u>217,456,960.32</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	121,654,537.89	93,078,317.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	121,654,537.89	93,078,317.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	121,654,537.89	93,078,317.00
31211	Төрийн сангийн харилцах	121,654,537.89	93,078,317.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	99,691,367.00	124,378,643.32
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	417,600.00	1,015,000.00
35130	Эм боох материал	417,600.00	1,015,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	97,543,767.00	121,563,643.32
35410	Бичиг хэргийн материал	1,969,000.00	4,204,580.00
35420	Аж ахуйн материал	4,513,100.00	4,232,100.00
35450	Барилгын засварын материал	1,472,000.00	2,292,600.00
35460	Хүнсний материал	6,905,360.00	10,238,020.00
35470	Бусад хангамжийн материал	82,684,307.00	100,596,343.32
35600	Мал амьтад	1,730,000.00	1,800,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>941,079,674.17</u></b>	<b><u>957,834,471.59</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	941,079,674.17	957,834,471.59
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	926,867,840.73	943,668,471.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	936,320,278.00	936,320,278.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-118,047,996.73	-143,463,544.21
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,994,440.00	5,994,440.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-3,996,293.28	-5,994,440.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	94,137,074.08	127,975,258.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-38,168,900.56	-46,325,682.09
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,740,324.25	22,226,024.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,924,019.93	-9,634,709.06
39214	Бусад үндсэн хөрөнгө	68,591,677.64	77,376,719.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-30,885,492.74	-24,044,622.38
39217	Ном	3,106,750.00	3,238,750.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	14,211,833.44	14,166,000.00
39301	Програм хангамж	137,500.00	137,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-91,666.56	-137,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,166,000.00	14,166,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b><u>1,162,425,579.06</u></b>	<b><u>1,175,291,431.91</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>1,780,800.00</u></b>	<b><u>7,862,993.06</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,780,800.00	7,862,993.06
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,780,800.00	7,862,993.06
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,780,800.00	7,862,993.06
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,160,644,779.06</u></b>	<b><u>1,167,428,438.85</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,160,644,779.06	1,167,428,438.85

**Хөвсгөл аймгийн Рашаант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	556,061,108.90	556,061,108.90
51101	Өмч: - төрийн	556,061,108.90	556,061,108.90
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	422,192,544.92	428,976,204.71
51210	Өмнөх үеийн үр дүн	422,192,544.92	422,192,544.92
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	6,783,659.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	182,391,125.24	182,391,125.24
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,162,425,579.06</b>	<b>1,175,291,431.91</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>815,582,031.00</b>	<b>1,031,362,373.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>42,011,242.00</b>	<b>70,451,173.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	42,011,242.00	70,451,173.00
120009	Бусад орлого	280,000.00	70,000.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/		
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/		
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>773,570,789.00</b>	<b>960,911,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	715,311,600.00	904,132,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	715,311,600.00	904,132,500.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих		
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,050,489.00	570,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,550,000.00	200,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,500,489.00	370,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	55,208,700.00	56,208,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,208,700.00	56,208,700.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>727,108,909.18</b>	<b>1,024,578,713.21</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>727,108,909.18</b>	<b>1,024,578,713.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	717,907,499.18	1,013,091,813.21
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	455,996,839.70	691,188,387.62
210101	Үндсэн цалин	332,191,180.28	458,096,649.69
210102	Нэмэгдэл	101,785,639.61	200,839,377.93
210104	Урамшуулал	22,020,019.81	32,252,360.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	57,999,997.88	86,648,658.27
210201	Тэтгэврийн даатгал	39,517,776.23	58,921,179.75
210202	Тэтгэмжийн даатгал	4,717,265.01	6,931,843.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,689,346.52	3,465,922.44
210204	Ажилгүйдлийн даатгал	882,287.35	3,465,922.44
210205	Эрүүл мэндийн даатгал	9,193,322.77	13,863,789.76
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	48,608,700.00	57,495,693.06
210301	Гэрэл, цахилгаан	5,400,000.00	6,345,209.66

**Хөвсгөл аймгийн Рашаант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210302	Түлш, халаалт	38,708,700.00	46,450,483.40
210303	Цэвэр, бохир ус	4,500,000.00	4,700,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,554,122.00</b>	<b>24,848,128.68</b>
210401	Бичиг хэрэг	2,369,578.00	5,256,970.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,033,350.00	14,330,700.00
210408	Бараа материал акталсны зардал	3,084,644.00	5,260,458.68
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>74,642,225.00</b>	<b>68,004,440.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	952,300.00	402,600.00
210502	Хоол, хүнс	73,689,925.00	67,601,840.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,418,000.00</b>	<b>3,045,130.00</b>
210604	Урсгал засвар	4,418,000.00	3,045,130.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,192,900.00</b>	<b>1,194,700.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,192,900.00	1,194,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>60,494,714.60</b>	<b>80,666,675.58</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,944,000.00	24,859,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,789,300.00	1,588,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,761,414.60	54,218,725.58
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,201,410.00</b>	<b>11,486,900.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,201,410.00</b>	<b>11,486,900.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,201,410.00	11,486,900.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>88,473,121.82</b>	<b>6,783,659.79</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>88,473,121.82</b>	<b>6,783,659.79</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан кашигал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	556,061,108.90	182,391,125.24	333,719,423.10	1,072,171,657.24
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	556,061,108.90	182,391,125.24	333,719,423.10	1,072,171,657.24
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	88,473,121.82	88,473,121.82
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	556,061,108.90	182,391,125.24	422,192,544.92	1,160,644,779.06
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	556,061,108.90	182,391,125.24	422,192,544.92	1,160,644,779.06
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	556,061,108.90	182,391,125.24	422,192,544.92	1,160,644,779.06
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	6,783,659.79	6,783,659.79
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	556,061,108.90	182,391,125.24	428,976,204.71	1,167,428,438.85

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>773,570,789.00</b>	<b>960,911,200.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>773,570,789.00</b>	<b>960,911,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	715,311,600.00	904,132,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	715,311,600.00	904,132,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,050,489.00	570,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,550,000.00	200,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,500,489.00	370,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	55,208,700.00	56,208,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,208,700.00	56,208,700.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>671,119,297.58</b>	<b>974,527,920.89</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>671,119,297.58</b>	<b>974,527,920.89</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>661,917,887.58</b>	<b>963,041,020.89</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	455,996,839.70	691,188,387.62
210101	Үндсэн цалин	332,191,180.28	458,096,649.69
210102	Нэмэгдэл	101,785,639.61	200,839,377.93
210104	Урамшуулал	22,020,019.81	32,252,360.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	57,999,997.88	86,648,658.27
210201	Тэтгэврийн даатгал	39,517,776.23	58,921,179.75
210202	Тэтгэмжийн даатгал	4,717,265.01	6,931,843.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,689,346.52	3,465,922.44
210204	Ажилгүйдлийн даатгал	882,287.35	3,465,922.44
210205	Эрүүл мэндийн даатгал	9,193,322.77	13,863,789.76
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	48,608,700.00	50,208,700.00
210301	Гэрэл, цахилгаан	5,400,000.00	6,345,209.66
210302	Түлш, халаалт	38,708,700.00	39,163,490.34
210303	Цэвэр, бохир ус	4,500,000.00	4,700,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	63,943,550.00	70,934,500.00
210502	Хоол, хүнс	63,943,550.00	70,934,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,600,000.00	6,000,000.00
210604	Урсгал засвар	6,600,000.00	6,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,192,900.00	1,194,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,192,900.00	1,194,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	27,575,900.00	56,866,075.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,997,200.00	50,707,075.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,578,700.00	6,159,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,201,410.00</b>	<b>11,486,900.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,201,410.00</b>	<b>11,486,900.00</b>

**Хөвсгөл аймгийн Рашаант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,201,410.00	11,486,900.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>102,451,421.42</u></b>	<b><u>-13,616,720.89</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b><u>5,458,000.00</u></b>	<b><u>14,959,500.00</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b><u>5,458,000.00</u></b>	<b><u>14,959,500.00</u></b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b><u>5,458,000.00</u></b>	<b><u>14,959,500.00</u></b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,458,000.00	14,959,500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-5,458,000.00</u></b>	<b><u>-14,959,500.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>96,993,491.42</b>	<b>-28,576,220.89</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>24,661,046.47</b>	<b>121,654,537.89</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>121,654,537.89</b>	<b>93,078,317.00</b>

**2.5 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан**

SORT_ID	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	121,654,537.89	(121,654,537.89)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,024,652,400.00	933,278,720.89	91,373,679.11	91.0
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,024,652,400.00	933,278,720.89	91,373,679.11	91.0
4	Бараа, үйлчилгээний зардал	1,013,165,500.00	921,791,820.89	91,373,679.11	90.9
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	769,539,800.00	691,188,387.62	78,351,412.38	89.8
6	Үндсэн цалин	519,591,400.00	458,096,649.69	61,494,750.31	88.1
7	Нэмэгдэл	228,735,700.00	200,839,377.93	27,896,322.07	87.8
9	Урамшуулал	21,212,700.00	32,252,360.00	(11,039,660.00)	152.0
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,808,200.00	86,648,658.27	3,159,541.73	96.4
12	Тэтгэврийн даатгал	61,071,200.00	58,921,179.75	2,150,020.25	96.4
13	Тэтгэмжийн даатгал	7,183,100.00	6,931,843.88	251,256.12	96.5
14	ҮОМШӨ ний даатгал	3,592,200.00	3,465,922.44	126,277.56	96.4
15	Ажил үйлдлийн даатгал	3,592,200.00	3,465,922.44	126,277.56	96.4
16	Эрүүл мэндийн даатгал	14,369,500.00	13,863,789.76	505,710.24	96.4
30	Нормативт зардал	77,102,600.00	70,934,500.00	6,168,100.00	92.0
32	Хоол, хүнс	77,102,600.00	70,934,500.00	6,168,100.00	92.0
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,359,500.00	1,194,700.00	1,164,800.00	50.6
49	Мэдээллийн технологийн зардал	2,359,500.00	1,194,700.00	1,164,800.00	50.6
53	Бараа үйлчилгээний бусад зардал	74,355,400.00	71,825,575.00	2,529,825.00	96.6
54	Бараа үйлчилгээний бусад зардал	66,697,400.00	64,167,575.00	2,529,825.00	96.2
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,658,000.00	7,658,000.00	-	100.0
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,486,900.00	11,486,900.00	-	100.0
70	Бусад урсгал шилжүүлэг	11,486,900.00	11,486,900.00	-	100.0
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	11,486,900.00	11,486,900.00	-	100.0
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	904,843,900.00	904,702,500.00	141,400.00	99.98
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	904,273,900.00	904,132,500.00	141,400.00	99.98
99	Улсын төсвөөс санхүүжих	904,273,900.00	904,132,500.00	141,400.00	99.98
120	Нэмэлт санхүүжилтийн орлого	570,000.00	570,000.00	-	100.0

**Хөвсгөл аймгийн Рашаант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

123	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000.00	200,000.00	-	100.0
125	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	370,000.00	370,000.00	-	100.0
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	121,654,537.89	(121,654,537.89)	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	93,078,317.00	(93,078,317.00)	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	28.00	28.00	-	100.0
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
135	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	-	100.0
136	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	-	100.0

**Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:**

SORT_ID	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
296	ХӨТӨЛБӨР 71801	-	-	-	-
297	АРГА ХЭМЖЭЭ 80111	-	-	-	-
298	I НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	56,208,700.00	56,208,700.00	-	100.0
299	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	56,208,700.00	56,208,700.00	-	100.0
300	Бараа, үйлчилгээний зардал	56,208,700.00	56,208,700.00	-	100.0
313	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,208,700.00	50,208,700.00	-	100.0
314	Гэрэл цахилгаан	6,800,000.00	6,345,209.66	454,790.34	93.3
315	Түлш, халаалт	38,708,700.00	39,163,490.34	(454,790.34)	101.2
316	Цэвэр, бохир ус	4,700,000.00	4,700,000.00	-	100.0
330	Эд хогшил худалдан авах	6,000,000.00	6,000,000.00	-	100.0
334	Урсгал засвар	6,000,000.00	6,000,000.00	-	100.0
1471	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	56,208,700.00	56,208,700.00	-	100.0
1477	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	56,208,700.00	56,208,700.00	-	100.0
1478	Орон нутгийн төсвөөс	56,208,700.00	56,208,700.00	-	100.0
1501	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
1502	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
1503	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
1504	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
1507	АЖИЛЛАГСДЫН ТОО	28.00	28.00	-	100.0
1508	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
1509	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	-	100.0
1510	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	-	100.0

**5. Аудитын илрүүлэлт**

Аудитаар төсвийн зарцуулалт, хүүхдийн хоолны норм, норматив болон хөрөнгөтэй холбоотой 18,155.7 мянган төгрөгийн 3 зөрчил илрүүлж 3 зөвлөмж хүргүүлсэн.

**5.1 Аудитын залруулга**

Аудитын код: ХӨА-2025/206/НА-СТА-ТЗШ

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой залруулга хийгээгүй болно.

## 5.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

## 5.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

## 5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой

### Илрүүлэлт:

Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2024 оны 07 сарын 23-ны өдрийн А/28 тушаалаар байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад 1,777.5 мянган төгрөгийн урамшууллыг олгохдоо ажлын үр бүтээлийг үнэлсэн хангалттай баримтыг үндэслээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасныг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудыг урамшуулахдаа ажлын үр дүнг бодитой тооцож, улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулахгүй байхад анхаарч ажиллах

2. Хөрөнгийн данстай холбоотой

### Илрүүлэлт:

Тайлант онд үндсэн хөрөнгийн шинж чанартай 16,378.2 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 10.1.Үндсэн хөрөнгө нь бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэд ашиглах, бусдад түрээслүүлэх, эсхүл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа бөгөөд нэгээс дээш жилээр ашиглагдах биет хөрөнгө юм" гэж заасантай нийцээгүй ба санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг 2025 оны эхний хагас жилд багтаан бараа материал данснаас хасч үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, элэгдэл тооцох

### Илрүүлэлт:

3. Ахмадын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

### Илрүүлэлт:

Тус байгууллага нь Ахмадын тухай хуулийн холбогдох заалтын дагуу ахмадын сан байгуулж, жилийн төсөвтөө төлөвлөж батлуулаагүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт гусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай гэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална", Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-тай нийцэхгүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Ахмадын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хууль журмын дагуу байгууллагын төсвийн төсөлдөө ахмадын санг төлөвлөн батлуулж ажиллах

**Хөвсгөл аймгийн Рашаант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж, fas.audit.mn системд оруулж, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг гусгахгүй орхигдуулсан		Буруу гусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Урамшуулал олгох шийдвэр гаргахдаа ажлын үр дүнг бодит байдал нийцүүлэн үнэлээгүй зөрчил илэрсэн.	1	1,777.5					1	1,777.5
Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн	1	16,378.2					1	16,378.2
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>18,155.7</b>					<b>2</b>	<b>18,155.7</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ахмадын тухай хуулийн дагуу ахмадын сан байгуулж ажиллаагүй.	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Нийт дүн	3	18,155.7					3	18,155.7